

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан .....	3
2.1. Оршил.....	3
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	3
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	4
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	5
2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	7
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	11
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	11
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал .....	12
3.1 Зардлын данстай холбоотой асуудал.....	12
3.2 Зардлын данстай холбоотой асуудал.....	12
3.3 Зардлын данстай холбоотой асуудал.....	13
3.4 Зардлын данстай холбоотой асуудал.....	13
3.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал .....	14
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	15
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	16
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	19
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	21
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	22

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ШША	Шүүхийн шинжилгээний алба
ШШҮХ	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЗАХИРАЛ, БРИГАДЫН ГЕНЕРАЛ  
Д.БАТЖАРГАЛ ТАНАА

2020.03.25 № 01/930  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч тус хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсвийг зориулалтын дагуу зарцуулах, ажил гүйлгээг шууд зардлаар тусгахгүй байх, анхан шатны бүрдэл дутуу баримтаар данс бүртгэлд тусгахгүй байх, худалдан авах гэрээг дүгнэж баталгаажуулах, холбогдох тэмдэглэл акт үйлдэж байх, гэрээний хэрэгжилтийн талаарх ажлын тайлан бэлтгэх, Санхүүгийн тайланд бүх ажил гүйлгээг тусгах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсвийг үндэслэлтэй бодитой тоо мэдээнд үндэслэн төлөвлөх, байгууллага, салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдсан, холбогдох, хууль, дүрэм, журам, тогтоолыг бүрэн тусгасан бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллах, аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, актыг хэрэгжүүлж ажиллах, тогтоосон хугацаанд хэрэгжилтийг ирүүлэх, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 5-аас 2020 оны 3 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор Д.Цэгмиддорж хариуцан гүйцэтгэв.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 05/23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБООУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНБООУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

#### **Эрхэм зорилго:**

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь “Шүүхийн шинжилгээ явуулах эрх зүйн боловсронгуй орчин, оновчтой зохион байгуулалт, баталгаатай арга зүй, техник-технологийн дэвшлийг бүрэн ашиглах нөхцөлийг бий болгон, хүний нөөцийн чадварлаг баг бүрдүүлснээр аливаа хэргийг шинжлэх ухаанч нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Шүүхийн шинжилгээ явуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, шинжээч, мэргэжилтний эрх зүйн байдлыг улам тодорхой болгох;
- Шүүхийн шинжилгээ явуулах үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулж, шинжилгээг үр дүнтэй, хүртээмжтэй болгох;
- Шүүхийн шинжилгээний арга зүйг тодорхой болгож, шинжээчийн дүгнэлтийн нотолгооны ач холбогдлыг нэмэгдүүлэх;
- Шинжилгээний лабораториудыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн, дэвшилтэт техник төхөөрөмжөөр тоноглож, хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн, шуурхай, найдвартай байдлыг хангасан орчныг бүрдүүлэх;
- Судалгаанд суурилсан хүний нөөцийн бодлого боловсруулж, шинжээч, мэргэжилтнүүдийн чадварлаг баг бүрдүүлэх;

### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх үр дагавартай байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дотоод аудитын хэлтэс 2019 онд харьяа орон нутаг дахь 12 газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 25 зөвлөмж өгсөн байна. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж арга хэмжээ авч ажилласан байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 18 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 18 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувийг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 12,003.0 сая төгрөгийн 2 хувь буюу 240.1 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 12,155.6 сая төгрөгийн 2 хувь буюу 243.1 сая төгрөгөөр тогтоосон болно.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 23 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Үүнээс 3 санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 1 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 19 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт өгсөн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 18, Говьсүмбэр аймгийн Шүүхийн шинжилгээний алба “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,140.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,000.1 сая төгрөгийн 13 алдааг аудитын явцад залруулж, 5.1 сая төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 85.3 сая төгрөгийн 18 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 49.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 28 зөвлөмжийг хүргүүллээ.

### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 33.5 сая төгрөгөөр өр төлбөрийг дутуу, 0.03 сая төгрөгөөр татаас санхүүжилтийн авлагыг дутуу, 234.6 сая төгрөгөөр тайлант үеийн үр дүнг илүү нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 1.1 сая төгрөгөөр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг илүү, 1.1 сая төгрөгөөр ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд 234.6 сая төгрөгөөр тайлант үеийн үр дүнг илүү нэгтгэсэн;

### Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран ажиллах тухай 2019 оны 178 дугаартай 42.6 сая төгрөгийн гэрээ байгуулжээ. Дээрх гэрээтэй холбоотой Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн Мед Импекс интернэйшнл ХХК-тай ШШҮХ/201912010-01 дугаартай гэрээ байгуулсан байна. Хууль зүй, дотоод хэргийн яам болон Мед Импекс интернэйшнл ХХК-тай хийсэн гэрээний хугацаа дууссан боловч тус 2 гэрээг дүгнэж акт, протокол үйлдээгүй нийлүүлэгч Мед Импекс интернэйшнл ХХК-аас бараа материалыг бүрэн хүлээж аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Хууль зүй, дотоод хэргийн яамтай хийсэн 2019 оны 178 дугаар гэрээний 3.2-т "Гэрээ дуусах хугацаа 2019.12.20-ны өдөр", 4.5-д "Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь санхүүжилтийг авч ажлыг гүйцэтгэж дууссаны дараа ажлын тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд ирүүлнэ" Мед Импекс интернэйшнл ХХК-тай хийсэн 2019 оны ШШҮХ/201912010-01 дугаар гэрээний 4-т "Нийлүүлэгч нь Хар тамхины лаборатори эм урвалж, туслах материал, бусад нэр төрлийн барааг 2019 оны 11 дүгээр сарын 28-аас 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор бэлтгэн, хүлээлгэн өгнө" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Тус хүрээлэнгийн захирлын 2019 оны нэг удаагийн буцалтгүй тусламжийн тушаалын үндэслэл нь хөдөлмөрийн дотоод журмын 12 дугаар бүлэгт заасантай зөрчилдсөн, нэг удаагийн буцалтгүй тусламжийг харилцан адилгүй олгож, нийт 20.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Алба хаагч, ажилтнуудын албан тушаалын цалингийн сүлжээний шатлалыг шинэчлэн тогтоох, удаан жилийн нэмэгдлийн талаар тушаал шийдвэрийг тухай бүр гаргадаггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 216 оны А/07 дугаар тушаалаар баталсан хөдөлмөрийн дотоод журмын 12 дугаар бүлэгт заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.



3. Говьсүмбэр аймгийн “Шүүхийн шинжилгээний алба”-ны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Төвлөрүүлэн захирагчийн 76.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 5 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

### Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 495.2 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- Нийслэлийн Шүүхийн шинжилгээний албаны санхүүгийн байдлын тайлан болон өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх үеийн үр дүн 0.1 сая төгрөгөөр зөрүүтэй, цалингийн урьдчилгааг цалингийн өглөгөөр бүртгэсэн 363.9 сая төгрөгийг тус тус залруулсан;
- Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 1.5 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг ажиллагсдаас авах авлага дансанд, 67.9 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг цалингийн өглөг дансанд бүртгэсэн, санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогын дүнг аккрузал суурьт шалгах баланс, ерөнхий дэвтэр, ерөнхий журналын дүнтэй тулгахад үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжилт ерөнхий дэвтрийн дүнгээс 7.5 сая төгрөгөөр, ерөнхий журналын дүнгээс 3.8 сая төгрөгөөр, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого ерөнхий дэвтрийн дүнгээс 3.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан;
- Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба орон нутгийн хөрөнгө оруулалтаар 30.8 сая төгрөгийн үнэтэй автомашин бэлтгэж, орлогоор бүртгэснийг орон нутгийн өмчид бүртгэж, үндсэн хөрөнгийн данснаас 30.8 сая төгрөгөөр хасаж залруулсан байна.

## 2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

### 2.9.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 47.1 сая төгрөг болж, 21.8 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	68.9	47.1	21.8
<b>Дүн</b>	<b>68.9</b>	<b>47.1</b>	<b>21.8</b>

*Эх сурвалж: ШШҮХ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 0.6 сая төгрөг арилжааны банкны дансанд, 33.5 сая төгрөг барьцаа дансанд, 13.0 сая төгрөг ахмадын сангийн дансанд байршиж байна.

*Аудитын илрүүлэлт:*

- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 14.0 сая /Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн аппарат/

### 2.9.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 2.3 сая төгрөг болж, 0.9 сая төгрөгөөр өссөн /буурсан/ байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1.2	1.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	0.4	0.4
Татаас, санхүүжилтийн авлага	-	0.02	0.02
Бусад авлага	3.2	0.6	-2.6
<b>Дүн</b>	<b>3.2</b>	<b>2.3</b>	<b>0.9</b>

Эх сурвалж: ШШҮХ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд 2.3 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Ажилчидтай холбогдсон авлага 1.2 сая төгрөг;
- Төлбөрт үйлчилгээний орлогын авлага 0.4 сая ;
- Бусад авлага 0.7 сая төгрөг;

### 2.9.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 529.4 сая, эцсийн үлдэгдэл 590.2 сая төгрөг болж, 60.8 сая төгрөгөөр өссөн /буурсан/ байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалт	200.7	136.8	-63.9
Эм боох материал	11.4	14.9	3.5
Дуусаагүй үйлдвэрлэл	-	2.1	2.1
Бичиг хэргийн материал	11	8.4	-2.6
Аж ахуйн материал	28.7	38.8	10.1
Сэлбэг хэрэгсэл	15.9	3.2	-12.7
Түлш, шатах тос	12	9.1	-2.9
Хүнсний материал	-	2.4	2.4
Бусад хангамжийн материал	249.7	374.5	124.8
<b>Дүн</b>	<b>529.4</b>	<b>590.2</b>	<b>60.8</b>

Эх сурвалж: ШШҮХ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал өмнөх оноос өссөн шалтгаан нь нормын хувцас /борооны цув, мөрдөс, хээрийн хувцас, таних тэмдэг/ 124.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Нийслэлийн Шүүхийн шинжилгээний алба жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 1.6 сая төгрөгийн шатахууны үлдэгдлийг тоолоогүй, Сэлэнгэ аймгийн Шүүхийн шинжилгээний алба 3.8 сая төгрөгийн шатахууны зарцуулалтыг бөөн дүнгээр зардалд бүртгэсэн.
- Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь Сангийн яамны харилцах дансны хуулганы гүйлгээг Үндэсний татварын ерөнхий газрын e-tax.mn хаягийн И баримт болон И постын гүйлгээний дүнтэй тулгахад 81 гүйлгээний 19.5 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

## 2.9.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 19,489.0 сая, эцсийн үлдэгдэл 13,865.5 сая төгрөг болж, 5,623.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	8,235.6	8,886.7	651.1
Тээврийн хэрэгсэл	1,548.3	724.5	-823.8
Машин тоног төхөөрөмж	8,278.2	3,052.9	-5,225.3
Тавилга эд хогшил	486.4	219.8	-266.6
Дуусаагүй барилга	73.4	73.4	0.0
Бусад хөрөнгө	35.6	35.3	-0.3
Программ хангамж	18.3	50.0	31.7
Бусад биет бус хөрөнгө	813.2	822.9	9.7
<b>Дүн</b>	<b>19,489.0</b>	<b>13,865.5</b>	<b>-5,623.5</b>

/сая төгрөг/

Эх сурвалж: ШШҮХ.-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,144.5 сая, балансаас балансад шилжүүлэн авсан, үнэ төлбөргүй авсан нийт 286.5 сая төгрөгөөр нэмэгдсэн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолуудаар акталсан 565.2 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна. Тухайлбал:

### Барилга байгууламж:

Дорнод аймагт “Их базар констракшн” ХХК-аар 686.2 сая төгрөгийн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилга бариулж үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна.

### Тээврийн хэрэгсэл:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны А-1/3912, 418, 448 дугаар тогтоолоор 77.8 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл акталж, 58.9 сая төгрөгийн 2 тээврийн хэрэгсэл худалдан авсан байна.

### Машин тоног төхөөрөмж:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны А-1/3912, 418, 448 дугаар тогтоолоор 471.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж акталж, 261.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 53.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж байна.

### Тавилга эд хогшил:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны А-1/3912, 418, 448 дугаар тогтоолоор 15.7 сая төгрөгийн тавилга эд хогшил акталж данснаас хассан, худалдан авсан 90.5 сая төгрөг, шилжүүлэн авсан 3.0 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн.

### Дуусаагүй барилга:

Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний албаны байрны их засвартай холбоотой 73.4 сая төгрөгийн дуусаагүй барилга байгууламж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон улсын комиссын актаар хүлээн авсан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол шийдвэр гараагүйгээс шалтгаалж шилжүүлээгүй 686.2 сая төгрөгийн барилга бүртгэлтэй байна.

### Аудитын илрүүлэлт:

Төв, Говьсүмбэр аймгийн Шүүхийн шинжилгээний албаны эзэмшилд байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 43 нэр төрлийн 66.9 сая төгрөгийн цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг дахин үнэлээгүй, бодит үнэ цэнээр нь бүртгээгүй байна.

### 2.9.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 358.1 сая, эцсийн үлдэгдэл 197.9 сая төгрөг болж, 160.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	13.0	13.0
Хувь хүнд өгөх өглөг	322.2	149.8	-172.4
Байгууллагад төлөх өглөг	35.9	35.1	-0.8
<b>НИЙТ ДҮН</b>	<b>358.1</b>	<b>197.9</b>	<b>-160.2</b>

Эх сурвалж: ШШҮХ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн үлдэгдэл 197.9 сая төгрөг байна. Үүнээс барьцаа дансны өглөг 33.5 сая төгрөг, хувь хүмүүст 13.0 сая төгрөг, байгууллагад төлөх 1.6 сая төгрөг, тэтгэвэрт гарах тэтгэмжийн 149.8 сая төгрөгийн өртэй байна.

### 2.9.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 13,880.1 сая, эцсийн үлдэгдэл 14,307.2 сая төгрөг болж, 427.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт+/, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,170.8	6,053.2	-117.6
Хуримтлагдсан үр дүн	2,680.0	3,165.9	485.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,029.3	5,088.1	58.8
<b>Дүн</b>	<b>13,880.1</b>	<b>14,307.2</b>	<b>427.1</b>

Эх сурвалж: ШШҮХ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгийн өсөлт бууралтыг буруу тайлагнасан 117.6 сая төгрөгийн алдааг залруулсан.

### 2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орлогын төлөвлөгөөг 400.0 сая төгрөг, гүйцэтгэлээр 458.8 сая төгрөг буюу 14.7 хувиар давуулан биелүүлсэн байна. Зарим Шүүхийн шинжилгээний албаны орлогын төлөвлөгөө тасарсан байна. Тухайлбал:

Хүснэгт 7. Орлого

Байгууллага	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Сэлэнгэ аймгийн ШША	9.0	8.3	- 0.7
Завхан аймгийн ШША	3.9	3.8	- 0.1
Говьсүмбэр аймгийн ШША	3.2	3.0	- 0.2
<b>Нийт дүн</b>	<b>16.1</b>	<b>15.1</b>	<b>-1.0</b>

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрт зориулан 11,562.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 10,872.2 сая төгрөгийг урсгал зардалд, 690.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 11,162.2 сая төгрөгийг улсын төсвөөс 400.0 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Улсын төсвөөс 11,093.6 сая төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 458.8 сая төгрөг нийт 11,552.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж 99.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээнд 690.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 686.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, 33.5 сая төгрөгийг барьцаа дансанд, захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Баян-Өлгий аймгийн Шүүхийн шинжилгээний алба хандив тусламжаар 0.2 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс эзэнгүй цогцос оршуулах зардалд 229.4 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 214.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон давсан орлого 227.3 сая төгрөг, нийт 671.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа ажил үйлчилгээний зардалд 662.1 сая төгрөг, урсгал шилжүүлэгд 3.6 сая төгрөг, хөрөнгийн зардалд 5.8 сая төгрөг, нийт 656.6 сая төгрөгийг зарцуулсан 14.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад цалингийн зардалд давтан тооцоолол хийж амжаагүй болно.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 752 мэдээллийг хугацаанд нь, 109 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 21.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 6 зөвлөмж өгснөөс 5 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 83.3 хувьтай байна. Өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй асуудалд албан шаардлага өгсөн болно.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, гарын үсгийн бүрдэл дутуу 10.0 сая төгрөг, шууд зардлаар бүртгэсэн 3.1 сая төгрөг, баяр ёслолын үйл ажиллагаанд 0.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслээгүй байх;

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийг зориулалтын дагуу зарцуулах, ажил гүйлгээг шууд зардлаар тусгахгүй байх, Холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах, дотоод хяналтыг сайжруулах;

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### **3.2 Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран ажиллах тухай 2019 оны 134-1 дугаартай 19 нэр төрлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авах 172.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахад харьцуулалтын арга хэрэглэж 4 аж ахуй нэгжээс нийт 167.5 сая төгрөгөөр худалдан авсан байна. Худалдан авалттай холбоотой тооцоо нийлсэн, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

### 3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслээгүй байх;

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авах гэрээг дүгнэж баталгаажуулах, холбогдох тэмдэглэл акт үйлдэж байх, хууль тогтоомж, тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах, дотоод хяналтыг сайжруулах;

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## 3.3 Зардлын данстай холбоотой асуудал

### 3.3.1 Илрүүлэлт:

- Татварын тайлангаарх 1.8 сая төгрөгийн авлага, Шүүхийн шийдвэрийн тогтоолоор нөхөн төлбөрийн 0.2 сая төгрөгийн өглөгийг тус тус санхүүгийн тайланд тусгаагүй.
- Тус хүрээлэнгийн 2019 оны Б/11, Б/480 дугаар тушаалын үндэслэл дутуу хурлын шийдвэр бүрэн бус, ажилд томилох тушаалын үндэслэлд Засгийн газрын тогтоол, холбогдох хуулийг бүрэн оруулаагүй зэрэг 8.3 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Харьяа албаны цахилгаан, дулааны зардалд 4.2 сая төгрөгийг төлсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

### 3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслээгүй байх;

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд бүх ажил гүйлгээг тусгах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсвийг үндэслэлтэй бодитой тоо мэдээнд үндэслэн төлөвлөх, Засгийн газрын 1999 оны 38, 211 дүгээр тогтоол, 2012 оны 85 дугаар тогтоолыг тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах.

### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## 3.4 Зардлын данстай холбоотой асуудал

### 3.4.1 Илрүүлэлт:

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн аймаг, нийслэлийн салбар байгууллагуудын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 538.5 сая төгрөгийн

алдаа зөрчил илэрснээс 495.2 сая төгрөгийн 10 алдааг санхүүгийн тайланд залруулж, 5.0 сая төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 22.0 сая төгрөгийн 15 албан шаардлага хүргүүлсэн, 16.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах 23 зөвлөмжийг өгсөн.

#### 3.4.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, дүрэм, журам зөрчигдөх

#### 3.4.3 Өгсөн зөвлөмж:

Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, актыг хэрэгжүүлж ажиллах, тогтоосон хугацаанд хэрэгжилтийг ирүүлэх, дотоод хяналтыг сайжруулах.

#### 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **3.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал**

#### 3.5.1 Илрүүлэлт:

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн хэмжээнд мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллага, салбарын онцлог, үйл ажиллагаатай уялдаагүй, хууль, тогтоомж шийдвэрийн дагуу өөрчлөлт оруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн Үнэн зөв байдал, Үнэлгээ, Иж бүрэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

#### 3.5.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, дүрэм, журам зөрчигдөх

#### 3.5.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллага, салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдсан, холбогдох, хууль, дүрэм, журам, тогтоолыг бүрэн тусгасан бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллах, Төсвийн ерөнхийлөн захирагчийн мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрийн онцлог, үйл ажиллагааны талаар тусгуулах.

#### 3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



#### 4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	601,465.6	639,617.4
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	68,863.1	47,099.4
<b>АВЛАГА</b>	3,244.5	2,287.0
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	529,357.9	590,231.0
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	13,636,820.9	13,865,462.8
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	13,636,820.9	13,865,462.8
<b>Биет хөрөнгө</b>	12,820,366.4	12,992,596.2
<b>Биет бус хөрөнгө</b>	816,454.6	872,866.6
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	14,238,286.5	14,505,080.1
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	358,125.0	197,875.8
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	358,125.0	197,875.8
<b>Өглөг</b>	358,125.0	197,875.8
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	13,880,161.5	14,307,204.4
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	13,880,161.5	14,307,204.4
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,170,802.7	6,112,002.7
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,680,047.8	3,107,090.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,029,311.0	5,088,111.0
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	14,238,286.5	14,505,080.1

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	15,349,162.1	12,584,263.1
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	4,136,345.5	750,097.4
Нийтлэг татварын бус орлого	4,136,345.5	750,097.4
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	11,212,816.6	11,834,165.6
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	10,911,304.6	12,155,629.1
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	10,786,758.9	12,155,629.1
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	10,063,910.3	11,794,456.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,854,882.7	7,604,529.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	217,857.1	260,203.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	242,301.0	275,593.2
Хангамж, бараа материалын зардал	446,233.2	468,277.3
Нормативт зардал	993,870.9	1,323,579.2
Эд хогшил, урсгал засварын зардал	189,995.8	152,743.1
Томилолт, зочны зардал	125,392.8	122,269.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	145,650.0	166,010.4
Бараа үйлчилгээний бусад зардал	847,726.8	1,421,251.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	722,848.6	361,173.0
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	124,545.7	0.0
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	4,437,857.5	428,634.0
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	1,091,690.5	399.8
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	3,346,167.0	428,234.2

#### 4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	12,028,047.5	12,333,868.1
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	815,230.8	503,945.8
Нийтлэг татварын бус орлого	815,230.8	503,945.8
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	11,212,816.6	11,829,922.3
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	10,078,363.1	11,211,137.3
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	10,078,363.1	11,211,137.3
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	9,676,625.7	10,678,514.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,850,491.8	7,604,223.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	221,031.9	260,787.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	244,218.4	275,685.5
Хангамж, бараа материалын зардал	418,307.6	442,435.8
Нормативт зардал	1,275,894.9	1,274,095.4
Эд хогшил, урсгал засварын зардал	200,856.0	267,642.6
Томилолт, зочны зардал	125,854.8	109,003.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,979.2	179,724.9
Бараа үйлчилгээний бусад зардал	188,991.0	264,916.6
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	401,737.4	532,622.6
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	1,949,684.4	1,122,730.8
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	1,893,055.8	1,144,494.5
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	1,893,055.8	1,144,494.5
Дотоод эх үүсвэрээр	1,893,055.8	1,144,494.5
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	-1,893,055.8	-1,144,494.5
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	56,628.6	-21,763.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,234.5	68,863.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	68,863.1	47,099.4

#### 4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	4,641,204.0	-	4,641,204.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	196,363.5	-	196,363.5
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	4,837,567.6	-	4,837,567.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	4,824,437.0	-	4,824,437.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	871,990.0	-	871,990.0
<b>Тайлант үеийн үр дүн</b>	3,346,167.0	-	3,346,167.0
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	13,880,161.5	-	13,880,161.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,191.3	-	-1,191.3
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	13,878,970.2	-	13,878,970.2
Тайлант үеийн үр дүн	428,234.2	-	428,234.2
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	14,307,204.4	-	14,307,204.4

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>11,562,224,900.0</b>	<b>11,552,390,244.6</b>	<b>9,834,655.4</b>	<b>99.9</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>10,872,224,900.0</b>	<b>10,866,160,544.6</b>	<b>6,064,355.4</b>	<b>99.9</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>10,420,543,000.0</b>	<b>10,414,478,644.6</b>	<b>6,064,355.4</b>	<b>99.9</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>7,586,133,700.0</b>	<b>7,585,623,825.1</b>	<b>509,874.9</b>	<b>100.0</b>
Үндсэн цалин	4,308,362,000.0	4,310,955,015.7	-2,593,015.7	100.1
Нэмэгдэл	2,582,276,700.0	2,583,155,488.0	-878,788.0	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	695,495,000.0	691,513,321.4	3,981,678.6	99.4
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>264,461,900.0</b>	<b>260,787,029.6</b>	<b>3,674,870.4</b>	<b>98.6</b>
Тэтгэврийн даатгал	96,970,800.0	101,203,436.1	-4,232,636.1	104.4
Тэтгэмжийн даатгал	9,280,800.0	8,085,931.4	1,194,868.6	87.1
ҮОМШӨ-ний даатгал	11,525,100.0	10,128,151.0	1,396,949.0	87.9
Ажилгүйдлийн даатгал	2,466,600.0	2,083,388.0	383,212.0	84.5
Эрүүл мэндийн даатгал	144,218,600.0	139,286,123.1	4,932,476.9	96.6
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>272,513,900.0</b>	<b>271,741,007.2</b>	<b>772,892.8</b>	<b>99.7</b>
Гэрэл, цахилгаан	78,305,000.0	77,894,792.4	410,207.6	99.5
Түлш, халаалт	147,169,000.0	148,079,073.5	-910,073.5	100.6
Цэвэр, бохир ус	33,139,900.0	32,241,041.3	898,858.7	97.3
Байрны түрээс	13,900,000.0	13,526,100.0	373,900.0	97.3
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>434,965,800.0</b>	<b>434,755,622.7</b>	<b>210,177.3</b>	<b>100.0</b>
Бичиг хэрэг	59,026,600.0	60,818,999.0	-1,792,399.0	103.0
Тээвэр, шатахуун	229,474,300.0	226,938,019.0	2,536,281.0	98.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	48,310,300.0	48,954,002.7	-643,702.7	101.3
Ном, хэвлэл	9,200,000.0	9,200,000.0	-	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	27,795,200.0	26,487,050.0	1,308,150.0	95.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	61,159,400.0	62,357,552.0	-1,198,152.0	102.0
<b>Нормативт зардал</b>	<b>1,252,808,400.0</b>	<b>1,252,805,720.1</b>	<b>2,679.9</b>	<b>100.0</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	634,225,700.0	632,635,809.1	1,589,890.9	99.7
Хоол, хүнс	90,407,700.0	92,117,956.0	-1,710,256.0	101.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	528,175,000.0	528,051,955.0	123,045.0	100.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>321,738,600.0</b>	<b>321,489,600.0</b>	<b>249,000.0</b>	<b>99.9</b>
Багаж, техник, хэрэгсэл	251,387,600.0	251,387,561.0	39.0	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	35,012,200.0	34,369,910.0	642,290.0	98.2
Урсгал засвар	35,338,800.0	35,732,129.0	-393,329.0	101.1
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>106,627,900.0</b>	<b>106,609,700.0</b>	<b>18,200.0</b>	<b>100.0</b>
Дотоод албан томилолт	106,627,900.0	106,609,700.0	18,200.0	100.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>161,065,400.0</b>	<b>160,438,740.0</b>	<b>626,660.0</b>	<b>99.6</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	104,822,200.0	104,820,391.0	1,809.0	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,140,000.0	2,140,000.0	-	100.0
Даатгалын үйлчилгээ	9,886,800.0	9,773,158.0	113,642.0	98.9
Тээврийн хэрэгслийн татвар	2,823,200.0	2,588,445.0	234,755.0	91.7
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,069,200.0	901,200.0	168,000.0	84.3
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,884,300.0	25,884,300.0	-	100.0
Газрын төлбөр	2,616,000.0	2,507,546.0	108,454.0	95.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,823,700.0	11,823,700.0	-	100.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>20,227,400.0</b>	<b>20,227,400.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,227,400.0	20,227,400.0	-	100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>451,681,900.0</b>	<b>451,681,900.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>451,681,900.0</b>	<b>451,681,900.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,634,800.0	47,634,800.0	-	100.0

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	381,214,100.0	381,214,100.0	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,833,000.0	22,833,000.0	-	100.0
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>690,000,000.0</b>	<b>686,229,700.0</b>	<b>3,770,300.0</b>	<b>99.5</b>
Барилга байгууламж	690,000,000.0	686,229,700.0	3,770,300.0	99.5
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>11,562,224,900.0</b>	<b>11,552,390,244.6</b>	<b>9,834,655.4</b>	<b>99.9</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>11,162,224,900.0</b>	<b>11,093,627,414.1</b>	<b>68,597,485.9</b>	<b>99.4</b>
Улсын төсвөөс санхүүжих	11,162,224,900.0	11,093,627,414.1	68,597,485.9	99.4
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>400,000,000.0</b>	<b>458,762,830.5</b>	<b>-58,762,830.5</b>	<b>114.7</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,000,000.0	458,762,830.5	-58,762,830.5	114.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,000.0		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	9,000.0		
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>1,051</b>	<b>1,051</b>		
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>23</b>	<b>23</b>		
Төсвийн байгууллага	23	23		
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>514</b>	<b>514</b>		
Удирдах ажилтан	23	24	-1	
Гүйцэтгэх ажилтан	475	474	1	
Үйлчлэх ажилтан	16	16		
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>514</b>	<b>514</b>		
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	498	498		
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16	16		

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>671,467,690.0</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>665,717,390.0</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>662,053,885.0</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>18,600,000.0</b>
Үндсэн цалин		16,500,000.0
Урамшуулал		2,100,000.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>3,944,450.0</b>
Түлш, халаалт		144,450.0
Байрны түрээс		3,800,000.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>10,560,170.0</b>
Бичиг хэрэг		712,000.0
Тээвэр, шатахуун		3,491,820.0
Ном, хэвлэл		3,500,000.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,856,350.0
<b>Нормативт зардал</b>		<b>23,772,000.0</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		23,347,000.0
Хоол, хүнс		425,000.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>341,511,800.0</b>
Багаж, техник, хэрэгсэл		291,528,100.0
Тавилга		2,216,200.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		657,500.0
Урсгал засвар		47,110,000.0
<b>Томилолт, зочны зардал</b>		<b>15,493,400.0</b>
Дотоод албан томилолт		2,393,400.0
Зочин төлөөлөгч хүлээн авах		13,100,000.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>41,939,765.0</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		21,234,765.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		20,705,000.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>206,232,300.0</b>
Бараа үйлчилгээний бусад зардал		202,232,300.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		4,000,000.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>3,663,505.0</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>3,648,600.0</b>
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		3,648,600.0
<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>14,905.0</b>
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		14,905.0
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>5,750,300.0</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>		<b>5,750,300.0</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		5,750,300.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>671,467,690.0</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>671,467,690.0</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		200,000.0
ЗГНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		229,423,370.0
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		214,504,900.0
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		227,339,420.0

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.03.25	Аудитын нэр:	<b>Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: САГ-2020/8/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн</b>		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Анхан шатны баримтын бүрдэл дутуу, гарын үсгийн бүрдэл дутуу 10.0 сая төгрөг, шууд зардлаар 3.1 сая төгрөг, баяр ёслолын зардалд 0.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.	14.0	Зөвлөмж	Санхүү төлөвлөлт хангамжийн газрын ерөнхий нягтлан бодогч, цагдаагийн ахлах дэслэгч	Э.Баянмөнх
2	Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран ажиллах тухай 2019 оны №134-1 дугаартай 19 нэр төрлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авах 172.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан, худалдан авах ажиллагаанд харьцуулалтын арга хэрэглэж 4 аж ахуй нэгжээс нийт 167.5 сая төгрөгөөр худалдан авсан байна. Худалдан авалттай холбоотой тооцоо нийлсэн акт, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.	5.0	Зөвлөмж	Санхүү төлөвлөлт хангамжийн газрын ерөнхий нягтлан бодогч, цагдаагийн ахлах дэслэгч	Э.Баянмөнх
3	Татварын тайлангаар 1.8 сая төгрөгийн авлага, Шүүхийн шийдвэрийн тогтоолоор нөхөн төлбөрийн 0.2 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.  Тус хүрээлэнгийн 2019 оны Б/11, Б/480 дугаар тушаалын үндэслэл дутуу, хурлын шийдвэр бүрэн бус, ажилд томилох тушаалын үндэслэлд Засгийн газрын тогтоол, холбогдох хуулийг бүрэн оруулаагүй, 8.3 сая төгрөгийг зарцуулсан байна.  Харьяа албаны цахилгаан, дулааны зардалд 4.2 сая төгрөгийг төлсөн байна.	14.5	Зөвлөмж	Санхүү төлөвлөлт хангамжийн газрын ерөнхий нягтлан бодогч, цагдаагийн ахлах дэслэгч	Э.Баянмөнх



4	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн аймаг, нийслэлийн салбар байгууллагуудын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 538.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 495.2 сая төгрөгийн 10 алдааг санхүүгийн тайланд залруулж, 5.0 сая төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 22.0 сая төгрөгийн 15 албан шаардлага хүргүүлсэн, 16.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах 23 зөвлөмжийг өгсөн.	43.3	Зөвлөмж	Санхүү төлөвлөлт хангамжийн газрын дарга, цагдаагийн ахмад	Г.Оюунбат
5	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн хэмжээнд мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллага, салбарын онцлог, үйл ажиллагаатай уялдаагүй, хууль, тогтоомж шийдвэрийн дагуу өөрчлөлт оруулаагүй байна.	-	Зөвлөмж	Санхүү төлөвлөлт хангамжийн газрын дарга, цагдаагийн ахмад	Г.Оюунбат
6	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран ажиллах тухай 2019 оны 178 дугаартай 42.6 сая төгрөгийн гэрээ байгуулжээ. Дээрх гэрээтэй холбоотой Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн Мед Импекс интернэйшнл ХХК-тай ШШҮХ/201912010-01 дугаартай гэрээ хийсэн байна. Хууль зүй, дотоод хэргийн яам болон Мед Импекс интернэйшнл ХХК-тай хийсэн гэрээний хугацаа дууссан боловч тус 2 гэрээг дүгнэж акт, протокол үйлдээгүй нийлүүлэгч Мед Импекс интернэйшнл ХХК-аас бараа материалыг бүрэн хүлээж аваагүй байна.	42.6	Албан шаардлага	Санхүү төлөвлөлт хангамжийн газрын дарга, цагдаагийн ахмад	Г.Оюунбат
7	Тус хүрээлэнгийн захирлын 2019 оны нэг удаагийн буцалтгүй тусламжийн тушаалын үндэслэл нь хөдөлмөрийн дотоод журмын 12 дугаар бүлэгт заасантай зөрчилдсөн, нэг удаагийн буцалтгүй тусламжийг харилцан адилгүй олгож, нийт 20.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Алба хаагч, ажилтнуудын албан тушаалын цалингийн сүлжээний шатлалыг шинэчлэн тогтоох, удаан жилийн нэмэгдлийн талаар тушаал шийдвэрийг тухай бүр гаргадаггүй байна.	20.8	Албан шаардлага	Санхүү төлөвлөлт хангамжийн газрын дарга, цагдаагийн ахмад	Г.Оюунбат
8	Говьсүмбэр аймгийн "Шүүхийн шинжилгээний алба"-ны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан байна.		Албан шаардлага	Говьсүмбэр аймгийн Шүүхийн шинжилгээний албаны захирагч	Д.Цэдэвсүрэн



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25

№ 02/161

Улаанбаатар хот

САН-2020/8/СТА-773

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд хийсэн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Говьсүмбэр аймгийн “Шүүхийн шинжилгээний алба”-ны 2019 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага...”, 28 дугаар зүйлийн 28.1-д “Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нөлөөлөхийг оролдсон, санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох буруутай албан тушаалтанд сахилгын хариуцлага хүлээлгэх.
2. Биелэлтийг 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал, Санхүү, төлөвлөлт, хангамжийн газрын дарга цагдаагийн ахмад Г.Оюунбат нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР *[Signature]* Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТОР *[Signature]*

Д.ЦЭГМИДДОРЖ

ЗӨВШӨӨРСӨН:

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ, БРИГАДЫН  
ГЕНЕРАЛ *[Signature]* Д.БАТЖАРГАЛ  
САНХҮҮ ТӨЛӨВЛӨЛТ, ХАНГАМЖИЙН  
ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН АХМАД  
Г.ОЮУНБАТ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25

№ 02/162

Улаанбаатар хот

САГ-0000/8/СТА-773

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд хийсэн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус хүрээлэнгийн захирлын 2019 оны нэг удаагийн буцалтгүй тусламжийн тушаалын үндэслэл нь хөдөлмөрийн дотоод журмын 12 дугаар бүлэгт заасантай зөрчилдөж байна. Нэг удаагийн буцалтгүй тусламжийг харилцан адилгүй олгож байна. Нийт 20.8 сая төгрөгийг зарцуулсан байна.
2. Алба хаагч, ажилтнуудын албан тушаалын цалингийн сүлжээний шатлалыг шинэчлэн тогтоох, удаан жилийн нэмэгдлийн талаар тушаал шийдвэрийг тухай бүр гаргадаггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 216 оны А/07 дугаар тушаалаар баталсан хөдөлмөрийн дотоод журмын 12 дугаар бүлэгт заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нэг удаагийн буцалтгүй тусламжийг харилцан адил олгож байх, Хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллах, цалин хөлсийг тухай бүрт нь тогтоож хууль журмын дагуу олгох.
2. Биелэлтийг 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал, Санхүү, төлөвлөлт, хангамжийн газрын дарга цагдаагийн ахмад Г.Оюунбат нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР *[Signature]* Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТОР *[Signature]* Д.ЦЭГМИДДОРЖ

ЗӨВШӨӨРСӨН:

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ, БРИГАДЫН  
ГЕНЕРАЛ *[Signature]* Д.БАТЖАРГАЛ  
САНХҮҮ-ТӨЛӨВЛӨЛТ, ХАНГАМЖИЙН  
ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН АХМАД  
*[Signature]* Г.ОЮУНБАТ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тоогуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie\_Kheree\Alban\_Shaardlaa\2020\0324SAG5.Docx

001-80348



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25 № 02/160  
САГ- 2020/8/СТА-ТТЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд хийсэн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран ажиллах тухай 2019 оны 178 дугаартай 42.6 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. Дээрх гэрээтэй холбоотой Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн Мед Импекс интернэшнл ХХК-тай ШШҮХ/201912010-01 дугаартай гэрээ хийсэн байна. Хууль зүй, дотоод хэргийн яам болон Мед Импекс интернэшнл ХХК-тай хийсэн гэрээний хугацаа дууссан боловч тус 2 гэрээг дүгнэж акт, протокол үйлдээгүй байна. Нийлүүлэгч болох Мед Импекс интернэшнл ХХК-аас бараа материалыг бүрэн хүлээж аваагүй байна.



Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Хууль зүй, дотоод хэргийн яамтай хийсэн 2019 оны 178 дугаар гэрээний 3.2-т "Гэрээ дуусах хугацаа 2019.12.20-ны өдөр", 4.5-д "Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь санхүүжилтийг авч ажлыг гүйцэтгэж дууссаны дараа ажлын тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд ирүүлнэ" Мед Импекс интернэшнл ХХК-тай хийсэн 2019 оны ШШҮХ/201912010-01 дугаар гэрээний 4-т "Нийлүүлэгч нь Хар тамхины лаборатор эм урвалж, туслах бусад материал нэр төрлийн барааг 2019 оны 11 дүгээр сарын 28-наас 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө" гэж заасныг тус тус зөрчсөн байна.



Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

*Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

1. Хууль зүй, дотоод хэргийн яам, Мед Импекс интернэшнл ХХК-тай хийсэн гэрээний үүргийг бүрэн гүйцэтгэж хэрэгжүүлэх цаашид аливаа гэрээг бүрэн хэрэгжүүлж байх, гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж акт үйлдэж байх.
2. Биелэлтийг 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал, Санхүү, төлөвлөлт, хангамжийн газрын дарга цагдаагийн ахмад Г.Оюунбат нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГА

**ТОГТООСОН:**  
 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
 ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
 АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ  
 АУДИТОР  Д.ЦЭГМИДДОРЖ  
 9006109  
 9019120396

**ЗӨВШӨӨРСӨН:**  
 ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ  
 ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ, БРИГАДЫН  
 ГЕНЕРАЛ  Д.БАТЖАРГАЛ  
 САНХҮҮ, ТӨЛӨВЛӨЛТ, ХАНГАМЖИЙН  
 ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН АХМАД  
 Г.ОЮУНБАТ

*Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харцууцагч албан тушаалтанд харцуулага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*





